

АВТОМАШИН ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2021 оны ... сарын-ны өдөр

№

Улаанбаатар хот

Энэ гэрээг нэг талаас Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8, Финанс төв хаягт байрлах, 5435528 регистрийн дугаартай “Эрдэнэс Тавантолгой” ХК (цаашид “Худалдагч” гэх), түүнийг төлөөлж, нөгөө талаасхаягт байрлах, регистрийн дугаартай иргэн, хуулийн этгээд /аль тохирохыг бичих/ /цаашид “Худалдан авагч гэх/, түүнийг төлөөлж/шаардлагатай тохиолдолд/ нар /цаашид хамтад нь “Талууд” гэх/ Монгол Улсын Иргэний хуулийн 197 дугаар зүйлийн 197.2 дах хэсэг, 243-261 дүгээр зүйл, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Дуудлага худалдаа зохион байгуулах журам, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Дуудлага худалдаа зохион байгуулах комиссын 2021 оны ... дугаар сарын ..-ны өдрийн ... тоот шийдвэрийг тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэ гэрээний зорилго нь Худалдагч гэрээнд заасан эрхийн зөрчилгүй (эд хөрөнгийн марк, төрөл зэрэг мэдээллийг тусгах) (цаашид “Эд хөрөнгө” гэх)-ыг Худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх, худалдан авагч нь гэрээнд дурдсан нөхцөлөөр үнийг төлөхтэй холбоотой талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Гэрээний зүйл болох худалдах худалдан авах эд хөрөнгө нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэйулсад онд үйлдвэрлэгдсэн /нийт жил ашигласан/, “.....” маркийнөнгөтэй, /техникийн болон шаардлагатай үзүүлэлтүүдийг нэмэх/ байна. /Шаардлагатай бол гэрээний зүйлийн тодорхойлолтыг хавсралтад тусгана/

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1. Гэрээ нь гэрээ байгуулагдсан өдрөөс эхлэн хоногийн хугацаанд хүчин төгөлдөр байх бөгөөд талуудын гэрээгээр хүлээсэн үүрэг бүрэн биелэх хүртэл хугацаанд үйлчилнэ.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 3.1. Энэ гэрээний 1.2-д заасан эд хөрөнгийн нийт үнэ (.....) төгрөг байна. Энэ үнэ нь эцсийн үнэ байна.

- 3.2. Энэ гэрээний 3.1-д заасан үнэ нь дуудлага худалдаанд оролцож ялсан үнэ болно.
- 3.3. Худалдан авагч нь дэнчин болгон нийт (.....) төгрөг тушаасан бөгөөд уг дэнчин нь энэ гэрээний 3.1-д заасан үнэд тооцогдоно.
- 3.4. Худалдан авагч нь энэ гэрээ байгуулагдсанаас хойш 7 хоногт багтаан төлбөрийг Худалдагчийн нэр дээрх банкны тоот дансанд шилжүүлнэ.

ДӨРӨВ. ЭД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ

- 4.1. Худалдан авагч эд хөрөнгийн төлбөрийг гэрээнд заасны дагуу бүрэн төлснөөр эд хөрөнгийг өмчлөх эрхтэй болно.
- 4.2. Худалдагч эд хөрөнгө, түүнтэй холбоотой бичиг баримтыг гэрээний 3.1-д заасан төлбөр бүрэн төлөгдсөнөөс хойш ажлын 5 өдрийн дотор акт үйлдэж шилжүүлнэ.
- 4.3. Эд хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлэхтэй холбогдон гарах үйлчилгээний хураамж болон бусад зардлыг худалдан авагч хариуцна.

ТАВ. ХУДАЛДАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1. Худалдагч нь худалдан авагчид эрхийн доголдолгүй эд хөрөнгийг гэрээнд заасны дагуу хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 5.2. Худалдан авагч эд хөрөнгийн үнийг энэ гэрээний 3.4-т заасан хугацаанд төлөөгүй бол гэрээг цуцалж, дэнчинг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн орлого болгон авах эрхтэй.
- 5.3. Гэрээний үүргээ бүрэн зохих ёсоор биелүүлэх үүрэгтэй.

ЗУРГАА. ХУДАЛДАН АВАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1. Гэрээнд заасны дагуу эрхийн доголдолгүй эд хөрөнгийг актаар хүлээн авах эрхтэй.
- 6.2. Эд хөрөнгийн үлдэгдэл төлбөрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.
- 6.3. Худалдан авсан эд хөрөнгийн үнийг бүрэн төлснөөр эд хөрөнгө, өмчлөх эрхийг шилжүүлэн авах болон холбогдох баримтыг шаардах эрхтэй.
- 6.4. Эд хөрөнгийг хүлээлцэхээр тогтоосон хугацаанд хүлээн аваагүй тохиолдолд тухайн эд хөрөнгийг хадгалах, хамгаалах, арчлахтай холбогдон гарах зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.
- 6.5. Гэрээний үүргээ бүрэн зохих ёсоор биелүүлэх үүрэгтэй.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА

- 7.1. Талуудын аль нэг нь өөрийн гэм буруутай үйлдлийн улмаас нөгөө талдаа хохирол учруулсан бол хохирлыг бүрэн хариуцаж арилгах үүрэг хүлээнэ.

- 7.2. Худалдан авагч эд хөрөнгийн үнийг энэхүү гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бол худалдаж авах эрхээ алдана.
- 7.3. Худалдан авагч нь тогтоосон хугацаанд эд хөрөнгийг хүлээн аваагүй тохиолдолд эд хөрөнгө хүлээлцэхээр тогтоосон өдрөөс хойш гэмтэл, доголдлыг худалдагч хариуцахгүй болно.

НАЙМ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 8.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу биелүүлэх боломжгүй болсон бол нөгөө талдаа 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдож болно.
- 8.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн 30 хоногоос дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэж болно.
- 8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

ЕС. ГЭРЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

- 9.1. Талууд харилцан тохиролцооноор Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж талуудын гарын үсгээр баталгаажуулж, гэрээнд хавсаргана. Ийнхүү оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь энэ гэрээний нэгэн адил хүчин төгөлдөрт тооцогдох бөгөөд гэрээний салшгүй хэсэг байна.
- 9.2. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс шийдвэрлэж чадвал Монгол Улсын хуулийн дагуу, Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

АРАВ. БУСАД

- 10.1. Гэрээнд дурдаагүй нөхцөл байдал, асуудлыг шийдвэрлэхэд Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.
- 10.2. Талууд гэрээг гурван /3/ хувь үйлдэх ба гэрээний хувь тус бүр дээр гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 10.3. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр харилцана.
- 10.4. Гэрээ дор дурдсан хавсралттай байх ба хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

.....

.....

Хаяг:

Утас:

Факс:

Вэбсайт:.....

ХУДАЛДАН

ТӨЛӨӨЛЖ:

Хаяг:.....

Утас:.....

Вэбсайт:.....

АВАГЧИЙГ

.....

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ